

# ҮНДСЭН ХУУЛЬ



## Зорилт:

- Үндсэн хууль нь Монголын ард түмний гол хууль болохыг тайлбарлах

## Сэдвийн агуулга:

- Үндсэн хууль
- Хүний эрх, эрх чөлөө
- Үндсэн үүрэг, журамт үүрэг

## Сургалтын арга:

- Лекцийн арга
- Хэлэлцүүлэг



## Хичээлийн хэрэглэгдэхүүн:

- “Үндсэн хууль” видео

## Түлхүүр үг:

### Үндсэн хууль

Улс орны засаглалыг тодорхойлж, иргэний үндсэн эрх, үүргийг баталгаажуулж, төрийн эрх мэдлийг хуваарилж, төрийн байгууллагын тогтолцоо, үндсэн зарчмыг тогтоож, иргэний эрхийг хангахын тулд төрийн эрх мэдлийн дээд хязгаарыг тогтоосон гол хууль. Үндсэн хууль нь бүх хууль тогтоомжийн үндэс суурь болдог бөгөөд бусад хууль Үндсэн хуульд нийцэж байх ёстой.

### Хүний эрх

Хүний төрөхөөс заяасан, хүний зэрэгтэй амьдрахад шаардагдах наад захын баталгаа. Хүний эрх жам ёсны шинжтэй. Өөрөөр хэлбэл, хүний эдлэх эрхийг аль нэг төр, эсвэл хэн нэгэн хүн өгдөггүй, бүтээдэггүй. Гэхдээ хүний эрхийг Үндсэн хууль, олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлэгт хүний эрхийн гол гол зарчмуудыг нэрлэж тусгасан байдаг.

### Хууль

Нийгмийн харилцааг зохицуулахын тулд парламентаас батлан гаргасан, бүх нийтээр заавал дагаж мөрдөх ёстой эрх зүйн хэм хэмжээ. Монгол Улсын хуулийг зөвхөн Монгол Улсын Их Хурал ард түмний нэрийн өмнөөс батлан гаргадаг.

### Эрх чөлөө

Хүнээс салгах ёсгүй, эдлэх ёстой боломж.

## Үйл ажиллагаа

### 1. Сэдэлжүүлэлт

- Тоглоом: Хэн олон хууль нэрлэх вэ? Энэ тоглоомыг дараах хэлбэрээр тоглож болно. Үүнд:
  - Хүүхдүүд хэд хэдээрээ 1 минутад хуулийн нэр хэлж алхана. Хамгийн олон хуулийн нэр хэлж, алхсан нь хожно.
  - Мөн 1 минутад хуулийн нэр бичиж уралдаж болно.
- Тоглоом дууссаны дараа хүүхдүүдийн нэрлэсэн олон хуулиудын үндэс тулгуур болдог хуультай танилцах нь өнөөдрийн хичээлийн зорилго болохыг багш танилцуулна.

### 2. Шинэ мэдлэг бүтээх

#### Мэдээлэл цуглуулах

Сурагчийн гарын авлагаас "Үндсэн хууль" сэдвийг унших  
Үндсэн хууль гэж юу вэ? видеог үзэх

**Ярилцах:** Үндсэн хуулийн талаар ямар мэдээлэл цуглуулснаа дараах асуултын хүрээнд ярилцана. Үүнд:

- Үндсэн хуулийг яагаад "Ард түмний гол хууль" гэж нэрлэдэг вэ?
- Яагаад бусад бүх хууль Үндсэн хуульд нийцсэн байх ёстой вэ?
- Үндсэн хуульд ямар гол заалтууд байдаг вэ?
- Хүний эрх, үндсэн үүргийг яагаад заавал Үндсэн хуульд тусгадаг вэ?

### 3. Бататгал

- Дасгал ажлын хуудсыг хувилаад сурагчдад тарааж өгнө.
- Дасгалыг хэрхэн хийх зааврыг танилцуулж, гүйцэтгэх хугацаа олгоно.

#### Дасгал ажил 1.

Үндсэн хуулийн талаар олж мэдсэн зүйлийг дасгалын хуудсан дээр бичүүлнэ.

#### Хяналтын асуулт:

1. Үндсэн хууль гэж юу вэ?
2. Үндсэн хуулийг яагаад "Ард түмний гол хууль" гэж нэрлэдэг вэ?
3. Яагаад Үндсэн хуулийн өдрийг тэмдэглэдэг вэ?
4. Үндсэн хуулийг тооны хэлээр илэрхийнэ үү? Тухайлбал, хэдэн бүлэг, зүйлтэй, хэзээ батлагдсан...гэх мэт

Дасгал ажил 1.



ОВОГ, НЭР: \_\_\_\_\_

АНГИ: \_\_\_\_\_

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Монгол Улсын Үндсэн хуулийн талаар өөрийн олж мэдсэн зүйлийг бичнэ үү.



## ҮНДСЭН ХУУЛЬ